

**БАТЛАВ.  
МОНГОЛ УЛСЫН  
ТЭРГҮҮН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН САЙД**

**БАТЛАВ.  
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС  
БАЯЛГИЙН САЙД**

**БАТЛАВ.  
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР  
АМЬСГАЛЫН  
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД**

**Ж.ЭНХБАЯР**

**Г.ДАМДИННЯМ**

**Ц.САНДАГ-ОЧИР**

**БАТЛАВ.  
САНГИЙН САЙД**

**БАТЛАВ.  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**З.МЭНДСАЙХАН**

**С.АМАРСАЙХАН**

2026 оны .... дугаар сарын ....-ний өдөр

**“УУЛ УУРХАЙН ЗАРИМ ТӨСЛҮҮДИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН  
ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг. Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах болсон  
үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт алтны олборлолтыг нэмэгдүүлэх, алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах, уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин, экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нөөц нь тогтоогдсон, дэд бүтцийн тодорхой бэлтгэл хангагдсан алтны үндсэн ордуудыг хууль тогтоомжид нийцүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах шаардлага үүсээд байна.

Геополитикийн тодорхойгүй байдал, дэлхийн эдийн засгийн эрсдэл нэмэгдэж, алтны үнэ өндөр түвшинд хадгалагдан, төв банкнуудын алтны худалдан авалт өсөж байгаа нөхцөлд алтны олборлолт, Монголбанканд тушаах алтны хэмжээг нэмэгдүүлэх нь экспортын орлого, гадаад валютын улсын нөөцийг өсгөх, төлбөрийн тэнцэл болон төгрөгийн ханшид үзүүлэх дарамтыг бууруулах замаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх ач холбогдолтой.

Монгол Улсад нийт 494.3 тонн алтны нөөц бүртгэгдэж, алтны 597 тусгай зөвшөөрөл олгогдсон боловч Монголбанканд тушаасан алтны хэмжээ 2024 онд 16 тонн, 2025 онд 10 тонн болж буурсан бөгөөд 2026 оны эхний таван сарын алтны

экспорт 2.5 тонн болж, өмнөх оны мөн үеэс 27 хувиар буурсан байна. Иймд богино хугацаанд олборлолтыг нэмэгдүүлэх боломжтой төслүүдийг хэрэгжүүлэх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын нутагт байрлах Гацууртын алтны үндсэн ордын үйлдвэрлэлийн нөөц 42.3 тонн, Эрээн-Баавгайтын алтны үндсэн ордын үйлдвэрлэлийн нөөц 10.5 тонн бөгөөд хоёр ордын нийт 52.8 тонн үйлдвэрлэлийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой. Төслүүд хэрэгжсэнээр жил бүр Монголбанканд нийт 5 тонн орчим алт тушааж, 620-750 сая ам.долларын борлуулалтын орлого бүрдүүлэх боломжтой гэж урьдчилан тооцоод байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолоор Ноён уулын байгалийн нөөц болон дурсгалт газрын хилийн заагт Сэлэнгэ аймгийн Мандал сум, Төв аймгийн Борнуур, Батсүмбэр сумын зарим хэсгийг хамруулан дархан цаазат газрын ангиллаар улсын тусгай хамгаалалтад авсан. Уг хилийн зааг нь Гацуурт, Эрээн, Баавгайт ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн зарим талбайтай давхацсанаар төслүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, батлагдсан нөөцийг ашиглах боломж хязгаарлагдсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтаар Засгийн газрын өргөн мэдүүлснээр дархан цаазат газрын хилийн заагийг батлах, өөрчлөх бүрэн эрхийг Улсын Их Хуралд олгосон. Иймд тусгай хамгаалалтын үндсэн зорилго, Ноён уулын байгаль, түүх, соёлын өвийн хамгаалалтыг алдагдуулахгүй байх зарчмыг баримтлан, зөвхөн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайтай бодитоор давхцаж байгаа хэсгийн солбицол, хэмжээг нарийвчлан тогтоож, хилийн заагт өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Төслийг хойшлуулах нь Монголбанканд тушаах алтны хэмжээ болон экспортын орлогын бууралтыг нөхөх боломжийг алдах, гадаад валютын нөөц, төлбөрийн тэнцэлд үзүүлэх дарамтыг үргэлжлүүлэх, төслүүдийн хөрөнгө оруулалт болон Хөгжлийн банкны зээлийн эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэхгүй удаашруулах эрсдэлтэй. Иймд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан журмаар төслийг яаралтай хэлэлцүүлэхээр боловсруулна.

### **Хоёр. Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Тогтоолын төслийн зорилго нь Гацуурт, Эрээн, Баавгайтын алтны ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас Ноён уулын дархан цаазат газрын хилийн заагтай давхцаж байгаа хэсгийг тусгай хамгаалалттай газар нутгаас чөлөөлж, шинэчилсэн хилийн заагийг тогтоох, улмаар төслүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Тогтоол батлагдсанаар ашигт малтмал ашиглах эрх шууд үүсэхгүй бөгөөд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тусгай зөвшөөрлийг сэргээх холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллага тус бүрээр шийдвэрлэнэ. Түүнчлэн тусгай хамгаалалттай газар нутгийн үлдэх хэсэг болон түүх, соёлын өвийн хамгаалалтын дэглэмийг сулруулахгүй.

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсанаар үүсэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Тогтоолын төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагаврыг бий болно:

3.1. Гацуурт болон Эрээн-Баавгайтын ордын нийт 52.8 тонн үйлдвэрлэлийн нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн үндсэн нөхцөл бүрдэнэ;

3.2. Жил бүр Монголбанканд 5 тонн орчим алт тушаах боломж бүрдэж, экспортын орлого болон гадаад валютын улсын нөөц нэмэгдэн, төлбөрийн тэнцэл, төгрөгийн ханшийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлнэ;

3.3. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, бусад татвар, төлбөрийн орлого нэмэгдэж, улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн санд төвлөрөх орлого өснө;

3.4. Урьдчилсан тооцоогоор төслүүд хэрэгжих хугацаанд Үндэсний баялгийн санд нийт 4.4 тэрбум хүртэл ам.долларын орлого төвлөрүүлэх боломж бүрдэх бөгөөд уг тооцоог хөрөнгө оруулалтын гэрээ, татварын нөхцөл, төрийн оролцооны хэлбэр, алтны үнэ болон олборлолтын бодит төлөвлөгөөнд үндэслэн нарийвчилна;

3.5. Эрээн-Баавгайтын төслийг хэрэгжүүлэх замаар төсөл хэрэгжүүлэгчийн Хөгжлийн банканд төлөх зээлийн өрийг барагдуулах бодит эх үүсвэр бүрдэх боломжтой;

3.6. Шинэ ажлын байр, дотоодын худалдан авалт, тээвэр, үйлчилгээ болон орон нутгийн бизнесийн идэвхжил нэмэгдэж, бүс нутгийн эдийн засгийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ;

3.7. Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн зааг, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн давхцалыг эрх зүйн хувьд тодорхой болгож, газрын болон кадастрын мэдээллийн сангийн уялдаа сайжирна.

Тогтоолын төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчин, усны нөөц, биологийн олон янз байдал, түүх, соёлын өвд сөрөг нөлөө үзүүлэх, орон нутгийн иргэдийн санал, гомдол болон нийгмийн үл ойлголцол үүсэх, эдийн засгийн өгөөжийн тооцоо зах зээлийн нөхцөлөөс шалтгаалан өөрчлөгдөх эрсдэл байна. Эдгээр эрсдэлийг бууруулахын тулд ус ашиглалт, хаягдлын менежмент, хүдэр тээвэрлэлтийн маршрутыг хамгаалалтын бүсээс ангид төлөвлөх, нөхөн сэргээлт, уурхайн хаалтын санхүүгийн баталгааг олборлолт эхлэхээс өмнө бүрдүүлэх, хараат бус хяналт-шинжилгээ хэрэгжүүлэх, мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авна.

Хилийн заагийг тэмдэгжүүлэх, мэдээллийн сан болон кадастрын бүртгэлийг шинэчлэхтэй холбоотой төрийн байгууллагын зардлыг тухайн байгууллагын батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэхээр тооцно. Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, мониторинг болон санхүүгийн баталгааны зардлыг төсөл хэрэгжүүлэгч бүрэн хариуцна.

**Дөрөв. Тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдах талаар**

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан газар, түүний хэвлий, байгалийн баялаг төрийн нийтийн өмч байх, төрөөс байгаль орчныг хамгаалах, үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зарчим, чиг үүрэгтэй нийцүүлэн боловсруулна.

Тогтоолын төсөл нь Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтаар Улсын Их Хуралд олгосон дархан цаазат газрын хилийн заагийг өөрчлөх бүрэн эрхэд үндэслэнэ. Мөн Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Усны тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Үндэсний баялгийн сангийн тухай, Компанийн тухай, Татварын ерөнхий хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулан хэрэгжүүлнэ.

Тогтоолын төсөл батлагдсанаар дээр дурдсан хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүсэхгүй. Харин Монгол Улсын Их Хурлын 2020 оны 47 дугаар тогтоолоор баталсан Ноён уулын дархан цаазат газрын хилийн заагт холбогдох өөрчлөлт орж, шинэчилсэн хилийн зааг, эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг тогтоолын хавсралтаар батална.

Тогтоолын төсөл нь Монгол Улсын нэгдэн орсон байгаль орчин, биологийн олон янз байдал, соёлын өвийг хамгаалах олон улсын гэрээ, конвенцын зорилго, зарчимтай зөрчилдөхгүй байх бөгөөд төсөл хэрэгжүүлэхдээ тэдгээрээр хүлээсэн үүргийг хангана.

---oOo---